



БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*2020 оны I улирлын тайлан*

БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт .....	2
Зургийн жагсаалт .....	3
Товчилсон нэрсийн жагсаалт .....	3
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	4
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт.....	6
“Аудитын тухай” хуулийн хэрэгжилт.....	6
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт .....	6
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт .....	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт ..	7
Статистик үзүүлэлтүүд .....	7
Харилцагчид, зээлдэгчид .....	8
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид.....	8
Тархалт.....	9
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт .....	10
Мөнгөн хөрөнгө .....	11
Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	11
Факторингийн тооцооны авлага .....	11
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө.....	12
Бусад хөрөнгө.....	12
Зээл.....	12
Эргэлтийн бус хөрөнгө.....	14
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт .....	15
Санхүүгийн эх үүсвэр.....	16
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг .....	16
Бусад эх үүсвэр .....	16
ББСБ-аас гаргасан өрийн бичиг .....	17
Төслийн зээлийн санхүүжилт .....	18
Бусад өр төлбөр.....	18
Хувь нийлүүлсэн хөрөнгө .....	18
Бусад өмч, сангууд.....	19
Хуримтлагдсан ашиг/алдагдал .....	20
Хоёрдогч өглөг.....	20
Ашигт ажиллагаа.....	21
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд .....	23
Дүгнэлт .....	24

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл .....	4
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан балансын ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ .....	4
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа .....	4
Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл .....	7
Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/ .....	8
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл.....	8
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа .....	8
Хүснэгт 8 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт .....	9
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт .....	9
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ .....	10
Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/ .....	11
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	11
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	11
Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/ .....	11
Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/ .....	12
Хүснэгт 16 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	12

Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/ .....	13
Хүснэгт 19 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	14
Хүснэгт 20 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ .....	15
Хүснэгт 21 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/ .....	16
Хүснэгт 22 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/ .....	16
Хүснэгт 23 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/ .....	17
Хүснэгт 24 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /сая төгрөгөөр/ .....	17
Хүснэгт 25 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 26 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 27 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/ .....	18
Хүснэгт 28 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/ .....	19
Хүснэгт 29 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/ .....	19
Хүснэгт 30 Хуримтлагдсан ашиг/алдагдал.....	20
Хүснэгт 31 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/ .....	21
Хүснэгт 32 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/ .....	22
Хүснэгт 33 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/ .....	23

### Зургийн жагсаалт

Зураг 1 ББСБ-уудын тархалт.....	9
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	10
Зураг 3 Зээлийн багцын чанар .....	13
Зураг 4 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	15
Зураг 5 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	16
Зураг 6 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/ .....	17
Зураг 7 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	17
Зураг 8 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/.....	19
Зураг 9 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/ .....	21

### Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

## Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2020 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 540 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 ББСБ буюу 0.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 75 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2016-I	2017-I	2018-I	2019-I	2020-I
Шинээр олгосон	15	13	5	3	3
Хүчингүй	2	2	2	3	1
Түдгэлзүүлсэн	0	17	1	4	18
Сэргээсэн	0	0	1	4	1
<b>Нийт ББСБ</b>	<b>463</b>	<b>529</b>	<b>537</b>	<b>539</b>	<b>540</b>
Үүнээс: ХОН	52	65	76	77	75
Үүнээс: ГХО	28	33	28	27	28
Салбар	121	122	177	220	273
Төлөөлөгч	4	4	4	5	9

2020 оны I улиралд 3 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгож, 18 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлж, 1 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2020 оны I улирлын байдлаар 10 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан балансын ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2019.I	2020.I	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,395.5	1,776.8	27.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.2%	5.1%	0.9%
Нийт өөрийн хөрөнгө	1,061.4	1,288.4	21.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	31.7%	43.6%	11.9%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	832.4	951.5	14.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	90.7%	123.8%	33.1%
Нийт зээл	975.5	1,271.8	30.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.6%	7.5%	1.9%
Нийт орлого	75.4	101.8	35.0%
Нийт зарлага	44.4	60.3	35.8%
Цэвэр ашиг	31.0	41.5	33.8%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өсөж, банкны салбарын 5.1%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

2020 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар буюу 381.3 тэрбум төгрөгөөр өсөж 1.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 77.7 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 31.2 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 35.0 хувиар буюу 26.4 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 35.8 хувиар буюу 15.9 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 33.8 хувиар буюу 10.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2019.I	2020.I	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		539	540	1	0.2%
1	Зээл	493	495	2	0.4%
Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		351	339	-12	-3.4%
2	Факторинг	23	31	8	34.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	18	20	2	11.1%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	5	2	66.7%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	24	31	7	29.2%
6	Гадаад валютын арилжаа	155	157	2	1.3%
Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		44	45	1	2.3%
7	Итгэлцэл	31	38	7	22.6%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	9	10	1	11.1%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	36	5	16.1%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 540 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 823 төрлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 91.7% нь буюу 495 ББСБ зээлийн

үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 62.8% нь буюу 339 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 157 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 29.1 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 45 ББСБ нийт ББСБ-уудын 8.3% бүрдүүлж байна.

Гадаад валютын үйл ажиллагаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын тоо 1-ээр нэмэгдсэн ба энэхүү ББСБ-ын онцлог нь валют арилжааны цахим талбарыг бий болгосон бөгөөд хэн ч байсан сайтад хандан, ханшийн бүх мэдээллээ нэг дороос авах, харилцан тохиролцсон дүнгээр арилжаа хийх боломжийг бүрдүүлсэн юм.

Цахим талбарын давуу тал нь худалдах талд: цахимаар нэг дороос худалдан авагчдаа олох, салбарынхаа байр суурийг илүү гүн тогтоох боломжийг олгож байгаа бол худалдан авагч талд: төвлөрсөн ханшийн мэдээлэл, ханшаа тохиролцох боломжийг бий болгох юм. Одоогоор дөрвөн төрлийн валют буюу евро, ам.доллар, юань, иенээр арилжаа хийх боломжтой бөгөөд талууд заавал биеэр уулзахгүйгээр тохиролцсон ханшаа цахимаар, дансаар хийх бүрэн боломжийг бүрдүүлсэн систем юм.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл факторингийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 29.2 хувиар өссөн байна.

2020 оны I улирлын тайлан мэдээний ирц 96.1% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 540 ББСБ-аас 519 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 21 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

## Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ыг боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [370 дугаар ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4586 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [441 дүгээр ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4622 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам” батлах тухай тогтоолыг 2020 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [10 дугаар ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4672 дугаараар бүртгүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ төрлийн корона вирус (Covid-19)-ын улмаас дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж эхлээд байгаа энэ үед санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, харилцагч, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Санхүүгийн

зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн [122/58 тоот хамтарсан тушаалаар](#) өөрчлөлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэр гаргаад байна.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн [148 дугаар тогтоол](#)оор үүсээд байгаа эдийн засгийн хүндрэлтэй байдлын үед банк бус санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлж банк бус санхүүгийн байгууллагуудын улсын төсөвт жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлдэг зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан байна. Ингэснээр харилцагч, зээлдэгчдийнхээ өрийн дарамтыг багасгах боломжийг олгож байгаа юм.

**“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт**

2020 оны I улирлын байдлаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 540 ББСБ-ын 63.5% буюу 342 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 318 ББСБ хэрэгжүүлсэн байна.

**“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт**

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны

3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар [шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж](#), тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 495 ББСБ-ын 69.9% буюу 346 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

**“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.”

**Статистик үзүүлэлтүүд**

2020 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 8,104 хувь нийлүүлэгчдийн 540 ББСБ, 273 салбар нэгж, 9 төлөөлөгчийн газар, 3,168 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,203,682 харилцагч, 425,859 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

*Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл*

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	2,203,682	176,175	2,027,507	15,198	2,192,168	11,514	702,236	1,501,446	30,933
Үүнээс: Эмэгтэй	1,160,368	94,892	1,065,476	10,166	1,153,740	6,628	389,506	770,862	18,270
Эрэгтэй	1,033,232	71,261	961,971	4,682	1,028,376	4,856	312,644	720,588	12,525
Хуулийн этгээд	10,082	10,022	60	350	10,052	30	86	9,996	138
Итгэмжлэгчдийн тоо	2,434	2,161	273	-	2,433	1	215	2,219	240
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	276	171	105	-	251	25	86	190	-
Зээлдэгчдийн тоо	425,859	139,389	286,470	-	414,615	11,244	208,823	217,036	30,931
Хэвийн	376,179	124,609	251,570	-	367,330	8,849	184,349	191,830	26,400
Хугацаа хэтэрсэн	15,247	7,798	7,449	-	14,289	958	2,700	12,547	2,673
Чанаргүй:	34,433	6,982	27,451	-	32,996	1,437	21,774	12,659	1,858
-Хэвийн бус	12,117	1,931	10,186	-	11,546	571	8,725	3,392	308
-Эргэлзээтэй	12,988	1,861	11,127	-	12,434	554	8,483	4,505	428
-Муу	9,328	3,190	6,138	-	9,016	312	4,566	4,762	1,122
Зээлдэгчдийн насжилт	417,358	130,896	286,462	-	406,144	11,214	208,758	208,600	30,795
18-35 насны	223,295	53,338	169,957	-	218,538	4,757	121,215	102,080	13,026
36-45 насны	119,592	45,102	74,490	-	115,433	4,159	56,737	62,855	9,874
46-55 насны	56,814	24,339	32,475	-	55,134	1,680	23,491	33,323	5,605
55-аас дээш	17,657	8,117	9,540	-	17,039	618	7,315	10,342	2,290
Зээлдэгчдийн боловсрол	417,358	130,896	286,462	-	406,144	11,214	208,758	208,600	30,795
-Дээд	242,681	69,253	173,428	-	236,770	5,911	115,880	126,801	12,987
-Тусгай дунд	28,154	19,787	8,367	-	25,876	2,278	7,355	20,799	4,979
-Бүрэн дунд	120,540	29,981	90,558	-	118,529	2,011	72,826	47,714	6,167
-Дунд	20,803	10,514	10,289	-	20,069	734	9,525	11,278	6,597
-Бага	5,180	1,360	3,820	-	4,900	280	3,172	2,008	65

гэж заасны дагуу нэр бүхий 144 ББСБ, 3,084 удаагийн тохиолдлоор, 248.9 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 1 ББСБ, 19 удаагийн тохиолдлоор, 222.0 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

**“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт**

2020 оны I улирлын байдлаар нийт 157 ББСБ 346.8 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

## Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.3 дахин өсөж 2,203,682, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өсөж 425,859-д хүрлээ.

Нийт харилцагчдын 80.3% буюу 1,770,021 нь, зээлдэгчдийн 51.3% буюу 218,666 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 19.7% буюу 433,661, зээлдэгчдийн 48.7% буюу 207,193 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 12,308 буюу нийт харилцагчдын 0.6 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2016-I	2017-I	2018-I	2019-I	2020-I	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	904	1,098	5,711	7,207	8,104	897	12.4%
Ажилчдын тоо	2,000	2,150	2,511	2,820	3,168	348	12.3%
Харилцагчдын тоо	445,918	1,331,686	1,358,693	1,664,902	2,203,682	538,780	32.4%
Зээлдэгчдийн тоо	57,969	58,923	137,530	263,949	425,859	161,910	61.3%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	4.0%	4.1%	3.4%	3.4%	3.0%	-0.4 пункт	

## Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн 7,047 буюу 87.0% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,057 буюу 13.0% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,061 буюу 13.1% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 180 буюу 2.2% нь хөдөө орон нутгийн хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,104	2,064	6,040	68	7,924	180	7,047	1,057	1,088
Нийт ажилтнуудын тоо	3,168	2,860	308	142	2,973	195	176	2,992	302
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	1,857	1,669	188	82	1,726	131	135	1,722	181

Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудаас “Даш кредит ББСБ” ХХК цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ давхар эрхэлж байна. Хөдөө орон нутгийн 75 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 83 үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
<b>ТЗ-тэй ББСБ-ын тоо</b>	<b>540</b>	<b>530</b>	<b>10</b>	<b>45</b>	<b>465</b>	<b>75</b>	<b>4</b>	<b>536</b>	<b>28</b>	<b>512</b>
<b>ТЗ-тэй үйлчилгээний тоо</b>	<b>822</b>	<b>780</b>	<b>42</b>	<b>46</b>	<b>739</b>	<b>83</b>	<b>22</b>	<b>800</b>	<b>55</b>	<b>767</b>
<b>ТЗ-тэй үйл ажиллагааны тоо</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>2</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>8</b>
1 Зээл	495	485	10	-	422	73	4	491	28	467
2 Факторингийн үйлчилгээ	31	26	5	-	31	-	2	29	2	29
3 Төлбөрийн баталгаа гаргах	20	20	-	-	20	-	1	19	5	15
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	2	3	-	5	-	1	4	-	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	31	25	6	1	31	-	2	29	1	30
6 Гадаад валютын арилжаа	156	149	7	45	149	7	3	153	9	147
7 Итгэлцлийн үйлчилгээ	38	33	5	-	37	1	3	35	3	35
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	8	2	-	9	1	2	8	2	8
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	36	32	4	-	35	1	4	32	5	31
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-	-	-

## Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 86.1% буюу 465 ББСБ, салбаруудын 66.3% буюу 181 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 13.9% буюу 75 ББСБ, салбаруудын 33.7% буюу 92 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 1 ББСБ-уудын тархалт



2020 оны I улирлын байдлаар 73 ББСБ-ын 273 салбар бүртгэлтэй байна.

Хүснэгт 8 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	75	92	167	100%
Орхон аймаг	7	13	20	12.0%
Дархан-Уул аймаг	7	11	18	10.8%
Төв аймаг	11	2	13	7.8%
Дорнод аймаг	5	7	12	7.2%
Өвөрхангай аймаг	7	5	12	7.2%
Сэлэнгэ аймаг	6	6	12	7.2%
Өмнөговь аймаг	1	10	11	6.6%
Баянхонгор аймаг	4	5	9	5.4%
Дорноговь аймаг	2	6	8	4.8%
Хөвсгөл аймаг	3	5	8	4.8%
Сүхбаатар аймаг	4	3	7	4.2%
Увс аймаг	2	4	6	3.6%
Хэнтий аймаг	3	3	6	3.6%
Баян-Өлгий аймаг	3	1	4	2.4%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.4%
Завхан аймаг	2	2	4	2.4%

Ховд аймаг	1	3	4	2.4%
Архангай аймаг	1	2	3	1.8%
Дундговь аймаг	1	2	3	1.8%
Булган аймаг	2	-	2	1.2%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%

Хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	465	181	646	100%
Сүхбаатар дүүрэг	165	29	194	30.0%
Чингэлтэй дүүрэг	142	24	166	25.7%
Баянгол дүүрэг	71	30	101	15.6%
Баянзүрх дүүрэг	50	47	97	15.0%
Хан-Уул дүүрэг	30	19	49	7.6%
Сонгинохайрхан дүүрэг	6	26	32	5.0%
Багануур дүүрэг	1	4	5	0.8%
Налайх дүүрэг		2	2	0.3%
Сүхбаатар дүүрэг	164	27	191	30.0%

## Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2020 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.3 хувиар буюу 381.3 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 77.7 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2019.I дүн	Нийт дүнд эзлэх хувь	2020.I дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,344,050.1	96.3%	1,707,191.5	96.1%	363,141.4	27.0%
Мөнгөн хөрөнгө	315,791.7	22.6%	351,394.2	19.8%	35,602.5	11.3%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,828.5	0.1%	9,514.9	0.5%	7,686.4	420.4%
Зээл (цэврээр)	907,130.3	65.0%	1,187,728.6	66.8%	280,598.3	30.9%
Нийт зээл	975,538.4	69.9%	1,271,814.7	71.6%	296,276.3	30.4%
(Зээлийн эрсдэлийн сан)	68,408.2	4.9%	84,086.1	4.7%	15,677.9	22.9%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	5,742.8	0.4%	3,398.4	0.2%	-2,344.4	-40.8%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	10,184.3	0.7%	12,340.6	0.7%	2,156.3	21.2%
Бусад хөрөнгө	103,372.6	7.4%	142,814.7	8.0%	39,442.1	38.2%
Эргэлтийн бус хөрөнгө	51,436.9	3.7%	69,567.6	3.9%	18,130.7	35.2%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	63,651.1	4.6%	82,286.7	4.6%	18,635.6	29.3%
(Хуримтлагдсан элэгдэл)	12,214.2	-0.9%	15,719.1	0.9%	27,933.3	-228.7%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,395,487.0</b>	<b>100.0%</b>	<b>1,776,759.1</b>	<b>100.0%</b>	<b>381,272.1</b>	<b>27.3%</b>

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2016 оны мөн үед 634.1 тэрбум төгрөг байсан бол 2020 оны I улирлын байдлаар 2.8 дахин өсөж 1.8 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 3.2 дахин өссөнтэй холбоотой. Мөн факторингийн цэвэр авлагын хэмжээ 2016 оны мөн үед 1.2 сая төгрөг байсан бол 2020 оны I улирлын байдлаар 3.4 тэрбум төгрөгт хүрч өссөн байна.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш активтай 151 ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээ 1.3 их наяд төгрөг буюу салбарын нийт активын 71.1 хувийг бүрдүүлж байна. 1.9-2.5 тэрбум төгрөгийн активтай 83 ББСБ-ын 175.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө 9.9%, 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 306 ББСБ-ын 338.2 тэрбум төгрөгийн хөрөнгө салбарын нийт активын 19.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	964.5	58	54.3%	10.7%	5.5	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	298.4	93	16.8%	17.2%	5.3	2	3.8	1	-	-
1.9-2.5 тэрбум	175.8	83	9.9%	15.4%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	261.1	162	14.7%	30.0%	-	-	1.6	1	1.6	1
0.6-1.4 тэрбум	54.2	49	3.0%	9.1%	4.1	5	9.0	9	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	22.9	95	1.3%	17.6%	1.4	4	11.9	50	9.0	40
<b>НИЙТ</b>	<b>1,776.76</b>	<b>540</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>16.2</b>	<b>12</b>	<b>26.2</b>	<b>61</b>	<b>12.1</b>	<b>45</b>

## Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн 44.7% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 31.0% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 24.3% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>351.4</b>	<b>319.0</b>	<b>32.4</b>	<b>13.1</b>	<b>342.4</b>	<b>9.0</b>	<b>12.8</b>	<b>338.6</b>	<b>24.5</b>
Бэлэн мөнгө	157.1	154.9	2.2	11.9	150.9	6.2	0.4	156.6	2.9
Харилцах	109.0	86.7	22.3	1.2	106.8	2.2	7.9	101.1	16.4
Хадгаламж	85.3	77.4	7.9	0.1	84.7	0.6	4.4	80.9	5.2

ББСБ-ууд мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 48.6%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 6.8%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 90.8% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

## Богино хугацаат хөрөнгө оруулалт

2020 оны I улирлын байдлаар 16 ББСБ 9.5 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 29.3% буюу 2.8 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас, 70.7% буюу 6.7 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 94.1% буюу 8.9 тэрбум төгрөг нь хувьцаа, 5.8% буюу 555.1 сая төгрөг нь өрийн бичгээрх 0.1% буюу 5.0 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>БХХО (ЦЭВРЭЭР)</b>	<b>9,514.9</b>	<b>8,846.9</b>	<b>668.1</b>	<b>1.0</b>	<b>8,858.6</b>	<b>656.4</b>	<b>7,821.7</b>	<b>1,693.2</b>	<b>7,153.6</b>
Хувьцаа	8,954.8	8,286.8	668.1	1.0	8,298.5	656.4	7,266.6	1,688.2	6,598.5
Өрийн бичиг	555.1	555.1	-	-	555.1	-	555.1	-	555.1
Бусад	5.0	5.0	-	-	5.0	-	-	5.0	-
<i>Хөрөнгө оруулалтын үнэт цаас</i>	<i>6,722.4</i>	<i>6,643.4</i>	<i>79.0</i>	<i>-</i>	<i>6,721.4</i>	<i>1.0</i>	<i>6,677.5</i>	<i>44.9</i>	<i>6,598.5</i>
<i>Арилжааны үнэт цаас</i>	<i>2,792.5</i>	<i>2,203.5</i>	<i>589.1</i>	<i>1.0</i>	<i>2,137.2</i>	<i>655.4</i>	<i>1,144.2</i>	<i>1,648.4</i>	<i>555.1</i>

## Факторингийн тооцооны авлага

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2019.I		2020.I		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
Хэвийн	5,782.8	100.0%	3,455.4	100.0%	-2,327.4	-40.2%
Хугацаа хэтэрсэн	5,629.8	97.4%	3,274.3	94.8%	-2,355.5	-41.8%
Хуучин хэтэрсэн	95.3	1.6%	117.7	3.4%	22.4	23.5%
Чанаргүй	57.7	1.0%	63.4	1.8%	5.7	9.9%
Хэвийн бус	27.3	0.5%	0.0	0.0%	-27.3	-100.0%
Эргэлзээтэй	4.0	0.1%	24.6	0.7%	20.6	514.8%
Муу	26.4	0.5%	38.8	1.1%	12.4	46.9%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	40.0	0.7%	57.0	1.6%	17.0	42.5%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо нэмэгдсэн хэдий ч 2020 оны I улирлын байдлаар Улаанбаатар хотод байршилтай, уламжлалт санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа 4

ББСБ 181.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 57.0 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 3.4 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 31 ББСБ-уудын 27 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

### Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 2.2 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар өсөж 12.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
<b>ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)</b>	12,340.6	10,412.9	1,927.7	12,181.6	159.0	695.9	11,644.7	2,808.6	9,532.1
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	12,505.5	10,053.5	2,452.0	12,353.6	151.9	1,343.7	11,161.8	2,984.7	9,520.8
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	3,265.7	2,604.3	661.4	3,265.7	-	647.8	2,617.8	1,062.7	2,203.0
Өмчлөх бусад хөрөнгө	3,100.8	2,963.7	137.1	3,093.7	7.1	-	3,100.8	886.6	2,214.2

### Бусад хөрөнгө

2020 оны I улирлын байдлаарх 142.8 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 52.5% буюу 75.0 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 28.4% буюу 40.6 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 19.0% буюу 27.2 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 16 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>	142,814.7	128,266.3	14,548.4	422.9	138,785.4	4,029.4	13,532.3	129,282.4	25,000.5
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	75,037.6	69,395.8	5,641.8	-	73,965.8	1,071.8	4,167.1	70,870.5	13,327.8
-Үнэт цаасны	4,885.6	4,885.6	-	-	4,877.7	7.9	2,270.1	2,615.5	2,270.1
-Зээлийн	67,544.7	62,174.3	5,370.3	-	66,481.8	1,062.8	1,897.0	65,647.6	11,028.5
-Факторингийн	-	-	-	-	-	-	-	-	-
-Бусад	37.4	37.4	-	-	37.4	-	-	37.4	-
Авлага /цэврээр/	2,570.0	2,298.4	271.5	-	2,568.9	1.1	-	2,570.0	29.2
Нийт авлага	40,592.5	36,239.3	4,353.2	3.8	38,207.8	2,384.7	4,822.3	35,770.1	4,827.7
Хэвийн	42,101.9	36,988.1	5,113.8	3.8	39,704.5	2,397.5	5,062.2	37,039.7	5,234.5
Хугацаа хэтэрсэн	39,924.0	35,606.3	4,317.7	0.3	37,556.1	2,367.9	4,822.3	35,101.7	4,746.2
Чанаргүй:	505.5	465.5	40.0	3.5	490.2	15.3	-	505.5	56.2
-Хэвийн бус	1,672.4	916.3	756.1	-	1,658.1	14.3	239.9	1,432.6	432.1
-Эргэлзээтэй	87.0	86.8	0.2	-	85.3	1.7	-	87.0	0.2
-Муу	221.1	221.1	-	-	219.5	1.6	-	221.1	55.9
Нийт авлага (валютын)	1,364.4	608.4	756.0	-	1,353.3	11.0	239.9	1,124.5	376.0
Нийт авлага (төгрөгийн)	2,929.0	2,658.1	270.9	-	2,929.0	-	187.6	2,741.4	339.7
(Авлагын эрсдэлийн сан)	1,509.5	748.9	760.6	-	1,496.7	12.8	239.9	1,269.6	406.8
Бусад актив	27,184.7	22,631.3	4,553.4	419.1	26,611.8	572.9	4,542.9	22,641.8	6,845.0

### Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 30.9% буюу 280.6 тэрбум төгрөгөөр өсөж 2020 оны I улирлын байдлаар 1,271.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 84.1 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,187.7 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	1,187.7	1,024.5	163.2	1,160.2	27.5	132.9	1,054.8	169.9	1,017.8
Нийт зээл	1,271.8	1,103.3	168.5	1,239.0	32.8	137.4	1,134.4	180.9	1,090.9
Хэвийн	1,114.8	958.5	156.2	1,089.0	25.8	130.3	984.4	165.2	949.5
Хугацаа хэтэрсэн	50.7	44.3	6.4	49.6	1.1	2.6	48.1	3.1	47.6
Чанаргүй:	106.4	100.5	5.9	100.5	5.9	4.6	101.8	12.6	93.8
-Хэвийн бус	20.6	19.6	1.1	20.1	0.5	0.4	20.2	1.7	19.0
-Эргэлзээтэй	23.3	20.2	3.1	22.7	0.6	2.8	20.5	2.3	21.0
-Муу	62.5	60.7	1.8	57.7	4.8	1.4	61.1	8.6	53.8
(Зээлийн эрсдэлийн сан)	84.1	78.7	5.4	78.8	5.2	4.5	79.6	11.0	73.1
Нийт зээл (төгрөгийн)	1,236.3	1,070.0	166.2	1,203.7	32.6	126.0	1,110.3	165.7	1,070.6
Нийт зээл (валютын)	35.5	33.2	2.3	35.4	0.2	11.5	24.1	15.2	20.3
Зээлдэгчдийн тоо	425,859	139,389	286,470	414,615	11,244	208,823	217,036	30,931	394,928


Оны эхэнд 1.2 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 464.8 тэрбум төгрөгийн зээлийг 3.0 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 422.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2020 оны I улирлын байдлаар 1.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 1,114.8 тэрбум төгрөг буюу 87.6 хувийг хэвийн зээл, 50.7 тэрбум төгрөг буюу 4.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 106.4 тэрбум төгрөг буюу 8.4 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.1, 0.7 пунктээр тус тус буурч хэвийн зээлийн хэмжээ 0.9 пунктээр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 157.1 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 53.5%-д буюу 84.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 3 Зээлийн багцын чанар



Нийт олгосон зээлийн 72.0% буюу 334.7 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлд, 9.8% буюу 45.6 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 70.5% буюу 298.3 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 10.3% буюу 43.5 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Хэрэглээ	334.7	72.0%	298.3	70.5%	646.6	50.8%
Бөөний болон жижиглэн худалдаа	45.6	9.8%	43.5	10.3%	210.2	16.5%
Барилга	27.2	5.8%	24.3	5.8%	138.2	10.9%
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	10.1	2.2%	8.2	1.9%	60.2	4.7%
Уул уурхай, олборлолт	6.6	1.4%	11.0	2.6%	44.8	3.5%
Машин мотоциклийн засвар үйлчилгээ	6.9	1.5%	6.5	1.5%	27.2	2.1%
Боловсруулах үйлдвэрлэл	4.6	1.0%	5.3	1.2%	27.2	2.1%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3.8	0.8%	3.4	0.8%	23.5	1.8%
Бусад	25.4	5.5%	22.4	5.3%	94.0	7.4%
<b>Иргэн</b>	<b>428.5</b>	<b>92.2%</b>	<b>391.6</b>	<b>92.6%</b>	<b>1,105.2</b>	<b>86.9%</b>
<i>Хуулийн этгээд</i>	36.6	7.8%	31.2	7.4%	166.6	13.1%
<b>Нийт дүн</b>	<b>464.8</b>	<b>100.0%</b>	<b>422.9</b>	<b>100.0%</b>	<b>1,271.8</b>	<b>100.0%</b>

Олгосон зээлийн 92.2% буюу 428.5 тэрбум төгрөгийн зээлийг иргэдэд, 7.8% буюу 36.6 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 92.6% буюу 391.6

тэрбум төгрөг нь иргэдээс, 7.4% нь буюу 31.2 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

### Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2020 оны I улирлын байдлаар 85.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 15.7 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

*Хүснэгт 19 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/*

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	<b>69.6</b>	<b>62.9</b>	<b>6.7</b>	<b>0.4</b>	<b>68.2</b>	<b>1.3</b>	<b>9.2</b>	<b>60.4</b>	<b>10.5</b>
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	85.3	77.6	7.7	0.5	83.4	1.8	9.9	75.4	12.4
Барилга байгууламж	28.1	25.0	3.1	0.0	27.5	0.6	1.2	26.9	0.8
Техник хэрэгсэл	30.1	28.5	1.6	0.1	29.2	0.9	1.0	29.1	2.8
Тавилга эд хогшил	11.3	10.2	1.1	0.2	11.0	0.3	2.0	9.3	2.5
Дуусаагүй барилга	9.5	9.2	0.4	-	9.5	-	4.3	5.2	5.6
Биет бус хөрөнгө	6.3	4.8	1.5	0.2	6.3	0.1	1.3	5.0	0.7
(Хуримтлагдсан элэгдэл)	15.7	14.8	1.0	0.1	15.2	0.5	0.7	15.1	1.9
Барилга байгууламжийн	2.5	2.2	0.3	0.0	2.4	0.1	0.3	2.2	0.1
Техник хэрэгслийн	9.9	9.4	0.5	0.0	9.5	0.4	0.3	9.5	1.4
Тавилга эд хогшлын	3.4	3.2	0.2	0.1	3.3	0.1	0.1	3.3	0.4

## Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 59.5 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 20 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2019.I	Нийт дүнд эзлэх хувь	2020.I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
<b>Өр төлбөр</b>	334,072.3	23.9%	488,344.8	27.5%	154,272.5	46.2%
Санхүүгийн эх үүсвэр	66,059.6	4.7%	115,205.2	6.5%	49,145.6	74.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	148,497.2	10.6%	203,220.1	11.4%	54,722.9	36.9%
Бусад эх үүсвэр	14,373.9	1.0%	13,256.4	0.7%	-1,117.5	-7.8%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	29,415.8	2.1%	46,495.1	2.6%	17,079.3	58.1%
Төслийн зээлийн санхүүжилт	18,111.0	1.3%	20,612.6	1.2%	2,501.6	13.8%
Бусад өр төлбөр	57,614.8	4.1%	89,555.4	5.0%	31,940.6	55.4%
<b>Эздийн өмч</b>	1,061,414.7	76.1%	1,288,414.4	72.5%	226,999.7	21.4%
Хувьцаат капитал	832,359.0	59.6%	951,527.1	53.6%	119,168.1	14.3%
Бусад өмч	16,187.8	1.2%	32,841.8	1.8%	16,654.0	102.9%
Сангууд	653.6	0.0%	926.6	0.1%	273.0	41.8%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	211,377.7	15.1%	302,282.3	17.0%	90,904.6	43.0%
Хоёрдогч өглөг	836.6	0.1%	836.6	0.0%	0.0	0.0%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>1,395,487.0</b>	<b>100.0%</b>	<b>1,776,759.1</b>	<b>100.0%</b>	<b>381,272.1</b>	<b>27.3%</b>


2016 оны мөн үетэй харьцуулахад пассивын өсөлтийн 53.4 хувийг буюу 610.3 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2016 оны I улирлын байдлаар 341.3 тэрбум төгрөг байсан бол 2020 оны I улирлын байдлаар 2.8 дахин өсөж 951.5 их наяд төгрөгт хүрсэн байна.

Зураг 4 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



## Санхүүгийн эх үүсвэр

Зураг 5 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 21 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	115.2	77.1	38.1	114.1	1.1	41.7	73.5	32.2
-Төгрөгөөр	87.7	64.6	23.1	86.6	1.1	22.4	65.2	21.7
-Валютаар	27.6	12.5	15.1	27.6	-	19.3	8.2	10.4
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	38	33	5	37	1	3	35	3
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	30	26	4	29	1	3	27	3
Нийт итгэмжлэгчдийн тоо	2,434	2,161	273	2,433	1	215	2,219	240

Хамгийн өндөр дүнгээр 21.8 тэрбум төгрөгийг 117 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон итгэмжлэгчээс 1,017 хувь хүн, хуулийн этгээдээс 819.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

## Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2020 оны I улирлын байдлаар 89 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 203.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 22 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	203.2		171.6	31.6	202.7	0.5	35.2	168.0	50.8	152.4
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл /1 жил хүртэлх/	97.8	48.1%	72.3	25.5	97.4	0.3	22.4	75.4	35.8	62.0
Урт хугацаат зээл /1 жилээс дээш/	105.5	51.9%	99.3	6.1	105.3	0.2	12.8	92.6	15.0	90.5
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	120.3	59.2%	96.7	23.6	119.7	0.5	17.6	102.7	11.1	109.1
Валютаар	82.9	40.8%	74.9	8.0	82.9	-	17.6	65.3	39.6	43.3
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	137.1	67.5%	108.7	28.4	136.6	0.5	32.0	105.2	20.9	116.2
Зээл /төгрөгөөр/	120.3	59.2%	96.7	23.6	119.7	0.5	17.6	102.7	11.1	109.1
Зээл /валютаар/	16.9	8.3%	12.1	4.8	16.9	-	14.4	2.5	9.8	7.1
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	66.1	32.5%	62.8	3.2	66.1	-	3.2	62.8	29.8	36.2


## Бусад эх үүсвэр

2020 оны I улирлын байдлаар 6 ББСБ 6.2 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, 3 ББСБ 1.2 тэрбум төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй, 2 ББСБ 5.9 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарчээ.

	Дүн	Эзлэх хувь	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	6,179.0	12.0%	1,885.3	4,293.7	6,179.0	-	-	6,179.0	1,111.9	5,067.1
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	1,173.3	13.2%	5.0	1,168.3	1,173.3	-	1,076.4	96.8	-	1,173.3
Факторингийн үйлчилгээний өглөг	5,904.2	74.8%	5,904.2	-	5,904.2	-	0.0	5,904.2	-	5,904.2

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 3.6 тэрбум төгрөгөөр өссөн бол төлбөр тооцооны болон факторингийн үйлчилгээний өглөг 2.5 болон 2.2 тэрбум төгрөгөөр, бусад эх үүсвэрийн үлдэгдэл нийт дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум төгрөг буюу 7.8 хувиар буурсан байна.

Зураг 6 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/



Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

### ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2020 оны I улирлын байдлаар 29 ББСБ хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 276 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 46.5 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 24 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /сая төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК
<b>ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ</b>	<b>46,495.1</b>	<b>26,360.5</b>	<b>20,134.6</b>	<b>46,376.8</b>	<b>118.3</b>	<b>7,463.1</b>	<b>39,032.0</b>
Төгрөгөөр	40,875.6	24,087.4	16,788.3	40,757.3	118.3	5,825.3	35,050.3
Валютаар	5,619.4	2,273.1	3,346.3	5,619.4	-	1,637.8	3,981.7

Улаанбаатар хотын 29 ББСБ 40.8 тэрбум төгрөгийг төгрөгөөр, хөдөө орон нутгийн 5 ББСБ 5.6 тэрбум төгрөгийг валютаар татан төвлөрүүлсэн байна.

Зураг 7 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өрийн бичгийн үлдэгдэл 2016 оны мөн үеэс 38.3 дахин өсөж 46.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 2.2% байсан бол 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 9.8 пунктээр өсөж 12.1%-д хүрсэн байна.

### Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 43 ББСБ 20.6 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нээлттэй хувьцаат компанийн хувьд төслийн зээл санхүүжилтийн үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 25 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн 20,612.6	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт 19,495.0	Финтек 1,117.6	УБ 18,560.4	ХОН 2,052.2	ГХО 8,935.5	Дотоод 11,677.2
<b>Хугацаагаар</b>								
Богино хугацаат /1 жил хүртэлх/	3,300.8	16.0%	2,688.2	612.6	3,180.8	120.0	541.0	2,759.8
Урт хугацаат /1 жилээс дээш/	17,311.8	84.0%	16,806.8	505.0	15,379.7	1,932.2	8,394.5	8,917.4
<b>Төрлөөр</b>								
Засгийн газрын	960.0	4.7%	960.0	-	840.0	120.0	-	960.0
Гадаадын	8,677.5	42.1%	8,677.5	-	8,677.5	-	8,004.5	673.0
Дотоодын	8,096.5	39.3%	7,591.5	505.0	6,219.5	1,877.0	931.0	7,165.5
Бусад	2,878.6	14.0%	2,266.0	612.6	2,823.4	55.2	-	2,878.6
<b>Валютын төрлөөр</b>								
Төгрөгөөр	17,269.7	83.8%	16,152.1	1,117.6	15,219.4	2,050.2	5,594.5	11,675.2
Валютаар	3,343.0	16.2%	3,343.0	-	3,341.0	2.0	3,341.0	2.0

### Бусад өр төлбөр

2020 оны I улирлын байдлаар 495 ББСБ 89.6 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 24.1% буюу 21.6 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 75.9% буюу 67.9 тэрбум төгрөг нь бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 26 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн 89,555.4	Уламж- лалт 62,200.1	Финтек 27,355.2	ЗГВА 178.7	УБ 88,244.6	ХОН 1,310.7	ХК 16,029.1	ХХК 73,526.3	ГХО 15,705.9	Дотоод 73,849.5
<b>Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг</b>	<b>21,614.8</b>	<b>18,958.5</b>	<b>2,656.3</b>	<b>-</b>	<b>21,611.4</b>	<b>3.4</b>	<b>6,865.0</b>	<b>14,749.8</b>	<b>6,317.8</b>	<b>15,297.0</b>
<b>Ангиллаар</b>										
Зээлийн	13,344.1	12,497.6	846.5	-	13,343.2	0.9	4,575.0	8,769.0	4,668.8	8,675.2
Үнэт цаасны	561.0	228.9	332.1	-	561.0	-	215.0	346.0	-	561.0
Бусад	7,709.7	6,231.9	1,477.8	-	7,707.1	2.6	2,074.9	5,634.8	1,648.9	6,060.8
<b>Валютын төрлөөр</b>										
Төгрөгөөр	20,095.0	17,902.1	2,192.9	-	20,094.2	0.9	6,517.8	13,577.3	6,072.9	14,022.1
Валютаар	1,519.8	1,056.3	463.5	-	1,517.2	2.6	347.3	1,172.5	244.9	1,274.9
<b>Бусад пассив</b>	<b>67,940.6</b>	<b>43,241.7</b>	<b>24,698.9</b>	<b>178.7</b>	<b>66,633.3</b>	<b>1,307.3</b>	<b>9,164.0</b>	<b>58,776.5</b>	<b>9,388.1</b>	<b>58,552.5</b>

### Хувь нийлүүлсэн хөрөнгө


2020 оны I улирлын байдлаар 540 ББСБ-ын 951.5 тэрбум төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 749.7 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 476.5 сая төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.3% буюу 119.2 тэрбум төгрөгөөр өсөж 951.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт пассивын 53.6 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн 951,527.1	Уламжлалт 898,523.3	Финтек 53,003.8	ЗГВА 13,499.9	УБ 918,014.2	ХОН 33,513.0	ХК 28,804.8	ХХК 922,722.3	ГХО 90,199.8	Дотоод 861,327.3
Энгийн хувьцаа	951,253.9	897,984.0	53,269.9	13,499.9	917,783.2	33,470.7	29,074.5	922,179.4	90,082.4	861,171.5
Давуу эрхтэй хувьцаа	749.7	749.7	-	-	707.4	42.3	-	749.7	121.0	628.7
Халаасны хувьцаа	476.5	210.4	266.1	-	476.5	-	269.7	206.8	3.6	472.9

Хувьцаат капиталын хэмжээ 2016 оны мөн үеэс 2.8 дахин өсөж 951.5 тэрбум төгрөгт, давуу эрхийн хувьцаа 29.7 дахин өсөж 749.7 сая төгрөгт халаасны хувьцаа 2.3 дахин өсөж 476.5 сая төгрөгт хүрсэн байна.

Зураг 8 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 175 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 59.1% буюу 562.5 тэрбум төгрөг байна.

Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 365 ББСБ-ын 389.0 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 40.9 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 28 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	174.5	21	18.3%	3.9%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	261.0	91	27.4%	16.9%	2.5	1	2.7	1	-	-
1.9-2.5 тэрбум	127.1	63	13.4%	11.7%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	335.7	232	35.3%	43.0%	-	-	1.4	1	1.4	1
0.6-1.4 тэрбум	32.9	35	3.5%	6.5%	2.0	3	7.0	8	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	20.5	98	2.2%	18.1%	2.9	7	9.2	51	8.4	40
<b>НИЙТ</b>	<b>951.5</b>	<b>540</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>13.0</b>	<b>12</b>	<b>20.3</b>	<b>61</b>	<b>13.5</b>	<b>45</b>

### Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 2.0 дахин өсөж 32.8 тэрбум төгрөгт, сангууд 41.8 хувиар өсөж 926.6 сая төгрөгт хүрсэн байна. Бусад өмчийн өсөлтийн 94.7 хувийг 1 ББСБ-ын нэмж төлөгдсөн капиталын өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/

	Дун	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
<b>Бусад өмч</b>	<b>32,841.8</b>	<b>25,979.1</b>	<b>6,862.7</b>	<b>277.4</b>	<b>32,428.9</b>	<b>412.9</b>	<b>22,240.4</b>	<b>10,601.4</b>	<b>16,284.0</b>	<b>16,557.8</b>
Нэмж төлөгдсөн капитал	28,237.0	21,431.7	6,805.3	259.7	28,089.1	147.9	22,183.1	6,053.9	16,278.3	11,958.7
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,293.6	2,293.6	-	-	2,162.9	130.7	-	2,293.6	5.7	2,288.0
<b>Хандивын капитал</b>	<b>2,311.2</b>	<b>2,253.8</b>	<b>57.3</b>	<b>17.8</b>	<b>2,176.9</b>	<b>134.2</b>	<b>57.3</b>	<b>2,253.8</b>	<b>-</b>	<b>2,311.2</b>
<b>Сангууд</b>	<b>926.6</b>	<b>926.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>300.2</b>	<b>626.4</b>	<b>-</b>	<b>926.6</b>	<b>4.5</b>	<b>922.1</b>
Нөөцийн сан	677.2	677.2	-	-	234.9	442.3	-	677.2	-	677.2
Нийгмийн хөгжлийн сан	249.4	249.4	-	-	65.3	184.1	-	249.4	4.5	244.8

## Хуримтлагдсан ашиг/алдагдал

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 33.7% буюу 75.7 тэрбум төгрөгөөр өсөж 300.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 30 Хуримтлагдсан ашиг/алдагдал

	АШИГ/АЛДАГДАЛ						
	ХУРИМТЛАГДСАН		-Тухайн үеийн				
			-Хуримтлагдсан				
2019.1	224,586,513.1		101,131,273.6		123,455,239.6		
2020.1	300,311,262.1		140,168,365.2		160,142,897.0		
	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо
Уламжлалт	530	273,828,321.0	526	36,260,674.2	518	237,567,646.8	489
Финтек	10	28,453,961.9	10	5,226,271.4	10	23,227,690.5	10
ЗГВА	45	618,210.3	45	(131,178.4)	43	749,388.7	43
УБ	465	299,251,661.4	462	40,586,342.1	455	258,665,319.3	435
ХОН	75	3,030,621.5	74	900,603.5	73	2,130,018.0	64
ХК	4	24,388,138.6	4	4,978,886.9	4	19,409,251.7	4
ХХК	536	277,894,144.3	532	36,508,058.7	524	241,386,085.6	495
ГХО	28	24,694,948.9	28	5,087,326.8	28	19,607,622.1	26
Дотоод	512	277,587,333.9	508	36,399,618.8	500	241,187,715.2	473


## Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татсан ББСБ-уудын тоо болон хэмжээнд өөрчлөлт ороогүй ба 2020 оны I улирлын байдлаар 5 ББСБ 836.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

## Ашигт ажиллагаа

2020 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 101.8 тэрбум төгрөгийн орлого олж, 60.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж 41.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 9 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.1% буюу 26.4 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 35.9% буюу 15.9 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 33.9% буюу 10.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 31 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/

ОРЛОГО	2019.I	2020.I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	63,360,466.5	82,712,225.3	81.3%	19,351,758.8	30.5%
Хүүгийн бус орлого	9,940,034.3	16,660,356.0	16.4%	6,720,321.7	67.6%
- Санхүүгийн үйлчилгээний орлого	7,090,383.5	13,159,645.7	12.9%	6,069,262.2	85.6%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	770.7	498.9	0.0%	(271.8)	-35.3%
- Мөнгөн гүйвүүлгын орлого	230,682.9	242,521.0	0.2%	11,838.1	5.1%
- Картын үйлчилгээний орлого	-	485,736.4	0.5%	485,736.4	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	64,192.5	59,955.0	0.1%	(4,237.5)	-6.6%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	5,390,706.1	9,510,706.9	9.3%	4,120,000.8	76.4%
- Бусад	1,404,031.4	2,860,227.5	2.8%	1,456,196.1	103.7%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,051,276.3	2,426,252.0	2.4%	374,975.7	18.3%
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>75,351,777.1</b>	<b>101,798,833.3</b>	<b>100.0%</b>	<b>26,447,056.2</b>	<b>35.1%</b>
<b>ЗАРДАЛ</b>					
Хүүгийн зардал	6,006,529.4	11,811,982.1	19.6%	5,805,452.7	96.7%
Хүүгийн бус зардал	25,546,701.8	33,389,361.1	55.4%	7,842,659.3	30.7%
Болзошгүй эрсдэлийн зардал	8,548,575.9	10,151,771.1	16.8%	1,603,195.2	18.8%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	597,342.5	620,071.3	1.0%	22,728.8	3.8%
Орлогын албан татварын зардал	3,670,640.5	4,338,384.2	7.2%	667,743.7	18.2%
Ердийн бус зардал	-	318.0	0.0%	318.0	-
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>44,369,790.1</b>	<b>60,311,887.7</b>	<b>100.0%</b>	<b>15,942,097.6</b>	<b>35.9%</b>
<b>АШИГ</b>					
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>30,981,987.0</b>	<b>41,486,945.6</b>	<b>100.0%</b>	<b>10,504,958.6</b>	<b>33.9%</b>

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн бус орлого 67.6% буюу 6.7 тэрбум төгрөгөөр өсжээ. Энэхүү өсөлтийн 90.2 хувийг санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлт бүрдүүлж байна. Финтек буюу санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ-ууд зээлдэгчдийн хэрэглээнд зориулсан бичил зээл олгохдоо ихэвчлэн хүү тогтоохгүйгээр, шимтгэл авч байгаа нь энэхүү орлогыг нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна. Нийт 9.5 тэрбум төгрөгийн үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлогын 82.5% буюу 7.8 тэрбум төгрөгийг финтек үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудын орлого бүрдүүлж байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал байна. Хүүгийн зардал 96.7% буюу 5.8 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 57.4 хувийг бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардлын өсөлт бүрдүүлж байна.

Харин нийт зардлын өсөлтийн 49.2 хувийг хүүгийн бус зардлын өсөлт бүрдүүлж байна. Хүүгийн бус зардал нь өмнөх оны мөн үеэс 30.7% буюу 7.8 тэрбум төгрөгөөр өсөж 33.4 тэрбум төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 41.4 хувийг ажилтнуудын цалингийн зардал, 19.7 хувийг итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан зардлын өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 32 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Хүүгийн орлого	82,712.2	74,959.0	7,753.2	3.6	80,804.0	1,908.2	7,274.8	75,437.4	13,242.6	69,469.7
Хүүгийн бус орлого	16,660.4	7,957.5	8,702.9	295.2	16,534.5	125.9	6,847.8	9,812.5	1,457.6	15,202.8
- Санхүүгийн үйлчилгээний орлого	13,159.6	4,786.6	8,373.0	9.6	13,035.8	123.9	6,498.9	6,660.7	975.8	12,183.9
Итгэлцлийн үйлчилгээний орлого	0.5	0.0	0.5	0.0	0.5	0.0	0.0	0.5	0.0	0.5
Мөнгөн гуйвуулгын орлого	242.5	242.5	0.0	9.6	242.5	0.0	0.0	242.5	0.0	242.5
Картын үйлчилгээний орлого	485.7	485.7	0.0	0.0	485.7	0.0	0.0	485.7	0.0	485.7
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	60.0	58.1	1.9	0.0	55.0	5.0	0.0	60.0	0.0	60.0
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	9,510.7	1,661.4	7,849.3	0.0	9,415.4	95.3	6,498.9	3,011.8	300.9	9,209.8
Бусад	2,860.2	2,338.9	521.4	0.0	2,836.6	23.6	0.0	2,860.2	674.8	2,185.4
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,426.3	2,268.5	157.8	0.0	2,307.7	118.5	151.0	2,275.3	152.6	2,273.6
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>101,798.8</b>	<b>85,185.0</b>	<b>16,613.8</b>	<b>298.7</b>	<b>99,646.2</b>	<b>2,152.6</b>	<b>14,273.6</b>	<b>87,525.2</b>	<b>14,852.8</b>	<b>86,946.0</b>
<b>ЗАРДАЛ</b>										
Хүүгийн зардал	11,812.0	9,311.0	2,501.0	-	11,764.6	47.3	1,882.5	9,929.5	2,079.8	9,732.2
Хүүгийн бус зардал	33,389.4	26,745.1	6,644.3	421.3	32,490.7	898.7	5,174.2	28,215.1	5,699.4	27,689.9
Болзошгүй эрсдэлийн зардал	10,151.8	8,399.5	1,752.3	-	9,985.6	166.1	1,648.8	8,503.0	1,242.4	8,909.4
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	620.1	552.4	67.7	2.1	575.3	44.8	82.0	538.0	79.4	540.6
Орлогын албан татварын зардал	4,338.4	3,916.1	422.3	6.6	4,243.3	95.1	507.2	3,831.2	664.4	3,674.0
Ердийн бус зардал	0.3	0.3	-	-	0.3	-	-	0.3	-	0.3
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>60,311.9</b>	<b>48,924.3</b>	<b>11,387.5</b>	<b>429.9</b>	<b>59,059.9</b>	<b>1,252.0</b>	<b>9,294.7</b>	<b>51,017.2</b>	<b>9,765.5</b>	<b>50,546.4</b>
<b>АШИГ</b>										
ЦЭВЭР ОРЛОГО	41,486.9	36,260.7	5,226.3	(131.2)	40,586.3	900.6	4,978.9	36,508.1	5,087.3	36,399.6

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын 3.6 сая төгрөгийн хүүгийн орлогыг 3 ББСБ-ын банкнаар дахь харилцах дансны хүүгийн орлого бүрдүүлж байна.

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2020 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 540 ББСБ-ын 81.7% буюу 441 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 18.3% нь буюу 99 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 88 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 5 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 5 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 33 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /38 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /457 ББСБ/		ЗГВА /45 ББСБ/		Нийт /540 ББСБ/	
		√	X	√	X	√	X	√	X
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	37	1	452	5	-	-	534	6
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	37	1	452	5	-	-	534	6
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	38	-	455	2	-	-	538	2
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	36	2	407	50	42	3	485	55
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу )	38	-	432	25		-	515	25
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	37	1	451	6		-	533	7
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	38	-	456	1		-	539	1
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	38	-	456	1		-	539	1
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	38	-	454	3	XXX	-	537	3
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	38	-	457	-		-	540	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	38	-	457	-		-	540	-
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	38	-	457	-		-	540	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	38	-	457	-		-	540	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	38	-	456	1		-	539	1
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	38	-	447	10	39	6	524	16
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	38	-	XXX		XXX	-	540	-
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	38	-	457	-		-	540	-
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	37	1	440	17	44	1	521	19

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо  
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 55 ББСБ хангаагүй, хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 25 ББСБ дутуу байгуулсан, үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 19 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 16 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

## Дүгнэлт

2020 оны I улирлын тайлан мэдээг ирүүлбэл зохих 540 ББСБ-аас 519 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 21 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2020 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 8,104 хувь нийлүүлэгчдийн 540 ББСБ, 273 салбар нэгж, 9 төлөөлөгчийн газар, 3,168 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,203,682 харилцагч, 425,859 зээлдэгчид хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 465 ББСБ, 181 салбар Улаанбаатар хотод, 75 ББСБ, 92 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2020 оны I улирлын байдлаар ББСБ-уудын актив 1.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар буюу 381.3 тэрбум төгрөгөөр өсжээ.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 2.5 тэрбум хүртэл хөрөнгөтэй 389 ББСБ нийт активын 28.9 хувийг, 2.5 тэрбум ба түүнээс дээш хөрөнгөтэй 151 ББСБ нийт активын 71.1 хувийг бүрдүүлж байна.

Дэлхийн 213 гаруй улс оронд тархаад буй Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 дугаар тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулахаар, нөгөө талаас Банк бус санхүүгийн байгууллагуудаас төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх хугацааг түр хойшлуулахаар шийдвэрлэсэн.

ББСБ-ууд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийн хүрээнд зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирсан зээлдэгчдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу зээлийн гэрээний хугацааг сунгах, үндсэн төлбөрийн хугацаа хойшлуулах, эдгээр үйлчилгээг хураамж, шимтгэлгүйгээр шийдвэрлэх боломж олгох шийдвэрийг нийтээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 158 ББСБ-д 45.5 мянган зээлдэгч зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн 98.7% буюу 44.9 мянган зээлдэгчийн 57.4 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан байна.

Мөн 37 ББСБ олон нийтийн сүлжээгээр харилцагч, зээлдэгчдэдээ хүүгийн хувийг бууруулах, шимтгэл, хураамж авахгүй байх, зарим ББСБ-ууд амны хаалтны үйлдвэрт хүүгүй зээл олгох, эмч, багш, Онцгой байдал, Цагдаагийн албан хаагчдын цалингийн зээлийн хүүг өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд чөлөөлөх зэрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаа мэдэгдсэн бол нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 62 ББСБ нэгдэн Улсын Онцгой Комисст 100.0 сая төгрөгийг хандивласан байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөг байгаа нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 7.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 1,114.6 тэрбум төгрөг буюу 87.6 хувийг хэвийн зээл, 50.7 тэрбум төгрөг буюу 4.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 106.4 тэрбум төгрөг буюу 8.4 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 157.0 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 53.5%-д 84.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос харгалзан 0.1, 0.7 пунктээр тус тус буурсан бол хэвийн зээлийн хэмжээ 0.9 пунктээр өссөн байна.

Тайлант хугацаанд 464.8 тэрбум төгрөгийн зээлийг 3.0 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.6 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 27.5% буюу 488.3 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 72.5% буюу 1.3 их наяд төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. 2020 оны I улирлын байдлаар 1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 175 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 59.1 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-1.9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 232 ББСБ-ын 335.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө 35.3 хувийг эзэлж байгаа бол 1.4 тэрбумаас доош хөрөнгөтэй 133 ББСБ-ын 53.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө 5.7 хувийг бүрдүүлж байна.

2020 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 101.8 тэрбум төгрөгийн орлого олж, 60.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж 41.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна

Нийт ББСБ-ын 81.7% буюу 441 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 18.3% нь буюу 99 ББСБ зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа тул хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**